



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 362

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 5.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги”-ийн дунд хугацааны үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үнэлгээ хийх ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үнэлгээний дүнг 2015 оны 4 дүгээр улиралд Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Э.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д даалгасугай.


САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081302

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 09 сарын 17 өдрийн
362... дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: Э.Оюунсүрэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
- Нарийн бичгийн дарга: Д.Баясгалан, Хяналт - шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн
- Гишүүд:
- Б.Пүрэвжав, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
 - Т.Энхзаяа, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн
 - Б.Эрдэнэчулуун, Чих, хамар, хоолойн ерөнхий мэргэжилтэн
 - Л.Долгорсүрэн, "ЭМЖЖ" эмнэлгийн их эмч
 - Л.Бямбасүрэн, Монголын чих хамар хоолойн эмч нарын нийгэмлэгийн тэргүүн
 - Д.Арьяамаа, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн чих хамар хоолойн тасгийн эрхлэгч
 - Б.Баярсайхан, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн чих хамар хоолойн эмч

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 09 сарын 17 өдрийн
362 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

**“Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги”-ийн
дунд хугацааны үнэлгээ хийх ажлын удирдамж**

Улаанбаатар хот

2015.09.02

1. Үндэслэл:

Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2009 оны “Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги” (2010-2019 он) батлах тухай 303/126 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах.

2. Зорилго:

2009-2019 онд хэрэгжүүлэх “Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги”-ийн дунд хугацааны үнэлгээг хийж, стратегийн хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмжөөр хангах.

3. Үйл ажиллагааны чиглэл:

Стратегийн дунд хугацааны үнэлгээг дараах чиглэлээр хийнэ.

- “Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги”-ийн шалгуур үзүүлэлтийн биелэлт;
- Стратегийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан сайдын холбогдох тушаалын хэрэгжилт;
- Хамтран ажиллах байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаа;
- Нэмэлт шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авна.

Тухайн стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон бусад холбогдох материалд үндэслэн тоон болон чанарын үзүүлэлтэд үнэлгээ өгнө. Үйл ажиллагааны тайлантай танилцаж, холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад очиж газар дээр нь стратегийн хэрэгжилттэй танилцана.

4. Хамрах хүрээ:

- Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар
- Эрүүл мэндийн яамны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв
- БОЭТ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Дүүргийн Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг

- Өрх, сумын Эрүүл мэндийн төв

5. Хугацаа:

2015 оны 10-11 дүгээр сар

6. Хүрэх үр дүн:

Стратегийн дунд хугацааны үнэлгээний дүн, санал, зөвлөмж гарч, Эрүүл мэнд, спортын яамны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулагдсан байна.

